

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван
гуравдугаар хуралдааны тэмдэглэл /2015-06-04/**

Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар хуралдаан 2015 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 14 цаг 00 минутад Төрийн ордны "Б" танхимд болов.

Хуралдаанд УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Батсуурь, Уул уурхайн сайд Р.Жигжид, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн эдийн засаг, маркетингийн хэлтсийн дарга Д.Галбаатар, Монголын нүүрс ассоциацийн тэргүүн Л.Даваацэдэв, Оюутолгой компанийн ерөнхийлөгч Андре Вүүдлей, Монголросцветмет ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөх М.Болдбаатар, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн төлөөлөгч Н.Дорждарь, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн Л.Долгормаа, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Дэлгэрмаа нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 15 гишүүд оролцож, ирц 50 хувьтай байв.

Мөн хуралдаанд ОУИТБС-ын ОУ-ын удирдах хорооны дарга, хатагтай Клейр Шорт, бүсийн захирал ноён Ваутер Бистербос, Алекс Горди, Уул уурхайн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын уул уурхайн хэлтсийн дарга Б.Нэргүй, мэргэжилтэн Т.Зууннаст, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Б.Болормаа, ахлах мэргэжилтэн Г.Зулай, Татварын ерөнхий газрын газрын байцаагч Д.Энхтуяа, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Оюутолгой компанийн менежер Х.Лхамаа, Бороо гоулд компанийн менежер П.Болормаа, Саусгоби сэндс ХХК-ны хэлтсийн дарга Б.Алтанбагана, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Адам Смит интернэйшнл байгууллагын менежер П.Оюунбилэг, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг, Мэдээлэл технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Дэлгэрмаа удирдан явуулав.

Б.Дэлгэрмаа: ОУИТБС-ын арван гуравдугаар хуралдаан нээснийг мэдэгдье. Энэ өдрийн амрыг эрье. Эрхэм Сайд Р.Жигжид, хатагтай Клэйр Шорт Танаа, Үндэсний зөвлөлийн гишүүд, эрхэм зочид, энэхүү хуралдаанд оролцож байгаа төлөөлөгчид өө. Үндэсний зөвлөлийн хуралдааны хөтөлбөрийг урьдчилан хүргүүлсэн билээ. Манай ОУИТБС-ын Үндэсний зөвлөл их ажил хэрэгч хуралддаг, иргэний нийгэм, төрийн байгууллага, компанийн төлөөлөл бүхий өвөрмөц бүтэцтэй байгууллагын хувьд хариуцлагатайгаар ажиллаж сурсан, туршлага хуримтлуулсан байгууллага юм. Бид техникийн шаардлагын улмаас 30 минутын өмнө хурлаа дуусгах шаардлагатай байгаад Засгийн газрын нэрийн өмнөөс уучлалт хүсээд, хуралдаанаа эхэлснийг мэдэгдье. Хуралдааны журмын дагуу Уул уурхайн сайд, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн орлогч дарга Р.Жигжид үг хэлнэ.

Р.Жигжид: Эрхэм хатагтай Клэйр Шорт болон энэ хуралдаанд оролцогч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, сайн сайхны хүсэн мэндчилье.

Монгол улс ОУИТБС-д нэгдсэнээс хойш 9 дэх жилтэйгээ золгож байна. Өнөөдөр Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар хуралдааныг зохион байгуулж байгаадаа баяртай байна. Энэхүү хуралдаанд ОУИТБС-ын тэргүүн хатагтай Клейр Шорт болон албаны бусад хүмүүс оролцож байгаад баяртай байна. Монгол улс Эрдэс баялагийн салбар дахь ил тод байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа энэ цаг үед энэхүү хуралдаан болж байгаа нь хуулийн ач холбогдлыг өндөрсгөж байна. УИХ-ын 2014 оны 18 дугаар хуралдаанаас батлагдсан “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ын хүрээнд хариуцлагатай, ил тод уул уурхайг хөгжүүлэх олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэхээр заасан. Улмаар Засгийн газраас эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Энэхүү хуулийг батласнаар уул уурхай, газрын тосны салбарт ил тод байдлыг жинхэнэ утгаар нь хөгжүүлж, эрдэс баялагийн салбараас орж буй орлогыг олон нийтэд ил тод болгох, ингэснээр түүнийг нийтийн сайн сайхны төлөө захиран зарцуулах, оролцогч талуудын хариуцлагыг сайжруулах, сайн засаглалыг хөгжүүлэх нэгдсэн зохицуулалт бий болох юм. (Хэлсэн үгийг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Сайд Танд баярлалаа, Үндэсний зөвлөлийн арван хоёрдугаар хуралдааны шийдвэрийн дагуу таван ажлын дэд хэсэг байгуулсан. Үндэсний зөвлөл жилдээ нэг удаа хуралдаад, гол үйл ажиллагаагаа хуралдааны хэлбэрээр явуулж ирсэн. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ерөнхий сайдын ахлах зөвлөх ажилладаг уламжлалтай. Үүний дагуу би Ерөнхий сайдын ахлах зөвлөх болсны дараа Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж эхэлсэн. Энэ хугацаанд бид илүү ажил хэрэгч, илүү амьдралд ойр байлгах үүднээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах, мэдээлэл солилцох үүднээс ажлын дэд хэсгүүдийг байгуулан ажилласан. Манай УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Батсуурь үг хэлэхээр чуулганы хуралдааны дундуур орж ирсэн байгаа, Батсуурь дарга таныг үг хэлнэ үү гэж урьж байна.

Ж.Батсуурь: Та бүгдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн гишүүд, хатагтай Клэйр Шорт, эрхэм хүндэт хатагтай, ноёд оо. Хатагтай Клейр Шортыг манай улсад тавтай морилохыг хүсэж, чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлж байна. Та манай сайхан оронд дахин зочилж байгаад чин сэтгэлээсээ талархаж байна.

Монгол Улсын Их Хурлаас ил тод байдлыг эдийн засаг, нийгэм, улс төрийн бүхий л түвшинд хангахын төлөө ажиллаж байна. Тухайлбал, эдийн засгийн ил тод байдлын хуулийн төслийг хэлэлцэж байна. Ажлын хэсэг байгуулагдсан, даваа гаригт 13 цагаас ажлын хэсгийн хуралдаантай, та бүхэн оролцож саналаа оруулах нь нээлттэй байгаа. Энэ хэлэлцүүлгийн дараа эдийн засгийн байнгын хороо хуралдаж, их хурлаар хэлэлцэгдэж батлагдана гэдэгт би итгэлтэй байгаа. Бизнес хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, татварын ачааллыг бууруулах, тайлагнах журмыг хөнгөвчлөх, ил тод нээлттэй болгохын тулд энэхүү хуулийг хэлэлцэж байгааг та бүхэн мэдэж байгаа. Манай салбарыг яам, яамны удирдлагууд болон мэргэжлийн байгууллагууд дэмжиж байгаа гэдэгт би итгэлтэй байгаа. Үүнийг хэрэгжүүлснээр орлого, хөрөнгө ил болон хууль ёсны хяналтанд орсноор татварын суурь нэмэгдэнэ. Мөн эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль манай байнгын хороонд байгаа, удахгүй хэлэлцэгдэж батлагдана гэж найдаж байна.(Хэлсэн үгийг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Батсуурь гишүүндээ баярлалаа. Одоо санаачилгын ОУ-ын Удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт үг хэлнэ. Хатагтай маань цаг заваа гарган манай улсад айлчлан ирж, Үндэсний зөвлөлийн хуралд оролцож байгаад бид

их баяртай байна. Маргааш Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байгаа Бороо гоулдын уурхайтай танилцаж, газар дээрээ уул уурхай ямар байгаатай танилцах юм. Бид хэдийгээр сайн ажиллаж байгаа ч гэсэн таны нүдээр харахад газар дээр ямар байгааг үзээд сэтгэгдлээ хэлэх байх. Таныг үг хэлнэ үү гэж урья.

Хатагтай Клейр Шорт: Та бүхэнтэй энд дахин уулзахдаа таатай байна. Монгол Улсад ирсэнээс хойш 2 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд та бүхний гаргасан ахиц дэвшилтийг би сайшааж байна.

Хүндэт Уул уурхайн Сайд, МУ-ын Ерөнхий Сайдын ахлах зөвлөх, УИХ-ын гишүүдийн төлөөлөл, эрхэм гишүүдээ.

ОУИТБС-ын Олон улс дахь үе шатны хувьд бид Сиднейн бага хурлаас өмнө Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудын гурван талын түншлэлийг бий болгох талаар ярьж байсан. Учир нь эдгээр гурван тал нь бие биетэйгээ харилцдаггүй, ярилцдаггүй байлаа. Хэн юу хийгээд байна, мэдээ мэдээллийн хувьд байнга зөрчилддөг байсан гэсэн үг. Энэ зөрчлийг арилгахын тулд хийсэн хөдөлгөөн бол чухал байсан. Мэдээж, орлогыг ил болгох, түүний мэдээлэл маш чухал байлаа. Уурхайн компани хэдийг төлсөн, Засгийн Газар хэдийг хүлээж авсан, энэ нь хоорондоо таарч байна уу гээд. Учир нь газрын тос, уул уурхайн салбар нь дэлхийн хэмжээнд бүх юм нь нууцлаг явагддаг гэсэн уламжлалтайг бид мэдэж байгаа шүү дээ. Энэ нь цаашлаад авлигыг өөгшүүлэх байдлыг бий болгож байсан. Тэгэхээр бидний санаа бүхэлдээ бол эдгээр гурван талыг нэг дор авчирч бүх зүйлийг нээлттэй, ил тод болгоё гэдэг байсан. Ингэснээр мэдээ баримтыг цэгцэлж, хариуцлагыг өндөржүүлэх нь илүү ил тод болох юм. За би та бүхэнд хэлсэнчилэн, эхний үе шатанд бид зөвхөн орлого дээр анхаарч ажиллаж байлаа.

Гэтэл хэдэн жил ажилласны дараагаас хэрэв бид үнэхээр уул уурхайн салбарын зохицуулалтыг сайжруулахыг хүсэж байгаа юм бол бидэнд өргөн цар хүрээний тайлан хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон. Гэрээнд юу тусгагдсан талаарх мэдээлэл ил тод болох, лиценз олгох тогтолцоо ямар байгаа, хэн төлсөн, яаж хувиарласан, төрийн өмчит компаниудыг татаж оролцуулах, орон нутаг дахь төлбөр орлогын асуудал, тэр нь орон нутгийн иргэдийг дэмжиж тэтгэж байна уу гэх зэрэг нь ил тод болох талаар бид илүү идэвхжүүлэн ажиллах шаардлагатай болсон.

Та бүхэн санаж байгаа байх, энэ бүхнийг улам өргөжүүлж тайландаа тусгах нь бодит эрэлт хэрэгцээ юмаа гэдгийг бүгд зөвшилцөж Сидней бага хурлаас энэ шинэ стандартыг баталсан. Түүгээр ч барахгүй тайлан нь зүгээр л олон тоо баримт байх учиргүй юм. Тайланд мөн тайлбар, агуулга байх ёстой. Учир нь ОУИТБС-ын талаар сонирхсон аливаа иргэн уншаад, уул уурхайн салбар нь улс эх оронд маань ямар ач холбогдолтой, байгалийн нөөц хэр их байна, хэдэн жил ашиглагдах нь, юунд хөрөнгө оруулалт хийгээд байна, тогтвортой хөгжилд хэр хувь нэмэр оруулж байна, хөрөнгө оруулалт дуусаад, нөөц дууссан үед бид улс эх орныхоо ирээдүйд сайнаар ашиглаж болох нь уу гэх зэрэг мэдээллийг авах, дүн шинжилгээ хийх боломжтой болох юм. Тэгэхээр бид одоо ийм их эрэлт хэрэгцээтэй, чухал цаг үе дээр байна.

Монгол Улс бол жил жилийнхээ тайлангаар маш зузаан тайлан гаргаж өгдөг гэдгээрээ бол алдартай. Эхний үе шатанд танайх хамгийн их тайлан өгдөг байсан

улс юм. Үүний сөрөг тал нь ингэж их мэдээлэл боловсруулж байхад түүнийг нь хүмүүс ашиглаж чадах уу гэдэг гол асуулт гарсан.

Харин өнөө өглөө би ямар ажилтай танилцсан бэ гэхээр, танай шинэ “цахим тайлан”-ийн тогтолцоотой танилцлаа. Би маш их сэтгэл хангалуун байгаа. Энэ их тоо баримт, зузаан мэдээ мэдээллийг маш хэрэгтэй, энгийн байдлаар иргэдэд хүргэх боломжийг бий болгосон байна. Тэгэхээр миний бодлоор та бүхэн бусад орнуудаасаа түрүүлж хөгжиж явж байна гэсэн үг юм. Ийм ажлыг бид 50 гаруй гишүүн орнуудад идэвхжүүлэх, хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа бөгөөд **та нар бусдад үлгэр жишээ болж, бусад орнуудад заах хэмжээнд байна. Үүнд чинь талархамаар байна.** Тэгэхээр одоо УИХ-ын гишүүд, судлаачид, сэтгүүлчид, орон нутгийн иргэдэд эдгээр мэдээллийг уншиж ойлгоход хялбар болсон гэж бодож байна. Түүнчлэн ингэж чухал мэдээ мэдээлэл, тоо баримтыг олж авсанаар уул уурхайн салбарын зохицуулалт ямар байгаа, иргэдэд, улсад ашиг тус нь юу байна, ирээдүйд ямар ач холбогдолтой байна гэх зэрэг мэдээллийг авч болох болно. Тэгэхээр энэ бол дараагийн үе шатанд шийдвэрлэх чухал асуудал.

Та бүхэн бий болгосон цахим тайлангийнхаа амжилт дээрээ тулгуурлан цааш нь ОУИТБС-ын тайланг тусад нь гаргаж байх биш, Засгийн газрын тогтолцоог илүү найдвартай, ил тод болгох боломжтой болох байх гэж найдаж байна. Түүнчлэн ямар асуудал байна, ямар өөрчлөлт шинэчлэл хийх шаардлагатай байна, түүнийгээ сайн хэрэгжүүлж чадав уу, үүний үр нөлөө ямар байв, улс эх оронд яаж нөлөөлөв гэх зэргээр тайланд тусгах нь чухал юм. За тэгэхээр бид олон улсын түвшинд ийм байна. Бид мэдээ мэдээлэл, тоо баримтыг авлаа, гэхэд эх орондоо яаж ашигтай байдлаар байлгах, ядуу иргэдэд ашиг шимийг хэрхэн хүргэх вэ гэдгийг үзүүлэх нь дараагийн чухал ажил болоод байна. Дэлхий даяар энэ салбар нь тэгш бус байдлыг бий болгох хандлагатай байдаг. Үүнийг бид маш сайн анхааралдаа авах ёстой. Улсынхаа байгалийн нөөц баялагаас хүн бүр хүртэх ёстой.

Та бүхэнд цахим тайлангийн тогтолцоогоо бүрдүүлж чадсанд дахин баяр хүргэе. Бусад орнууд та бүхний хийснийг ирж харах, та бүхнээс суралцах хүсэлтэй байх болно. Тэгэхээр та бүхэн тоо баримтыг бодит амьдралд ашиглах, Монгол Улсад хэрэгтэй өөрчлөлт шинэчлэлийг бий болгох, хүн бүр ашиг шим хүртэх, тогтвортой, урт хугацааны үр шимийг бий болгох боломжтой болно гэдэгт итгэж байна. Монгол Улсын ОУИТБС-ын ажлын багийг сайшааж байна. Мөн бид цаашид ихийг хийх үлдэж байна. Баярлалаа

Б.Дэлгэрмаа: Ийм сайхан халуун дулаан баяр хүргэсэн, бидний хийсэн ажлын үр дүнг сайхан үнэлсэн хатагтай Клейрт баярлалаа. Монгол улс цахим системийг бусад оронд загвар болгохуйц хийсэн байна гэсэн үнэлгээг хүлээж авна гэдэг бол манай Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн хүчин чармайлт, ажлын албаны чадавхийг харуулсан гэж бодож байна. Маргааш уул уурхай ямар байгааг газар дээр нь үзээрэй. Манай улс их хэмжээний ашигт малтмалтай, уул уурхай ихээр хөгжсөн манай оронд цахим системийг ашиглаж байгаа нь том ололт юм.

Ажлын дэд ажлын хэсгүүдийг байгуулагдсан. Өнөөдрийн хуралдаанд төрийн байгууллагуудыг төлөөлж Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан

оролцож байгаад баяртай байна. Мөн төрийн бус байгууллагын төлөөлөгчид болон уул уурхайн компаниудын төлөөлөл оролцож байна.

Ш.Цолмон: 2015 оны нэгдүгээр сард хуралдсан Үндэсний зөвлөлийн арван хоёрдугаар хуралдааны шийдвэрийн дагуу таван ажлын дэд хэсэг байгуулагдсан. Нэгдүгээр ажлын хэсэг уул уурхайгаас орж байгаа орлогыг тодорхой болгох зорилгоор Н.Дорждарь ахлан ажиллаж байгаа. Хоёрдугаар ажлын хэсэг нь байгаль орчны барьцаа хөрөнгийг жигд болгох, барьцаа төлбөрийн хэмжээг тодорхой болгохоор байгуулагдсан. Үүнийг Байгаль орчны хүрээлэн буй орчны газрын дарга Н.Нямдаваа ахлаж байна. Гуравдугаар ажлын хэсэг нь ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах, тайлангийн маягтыг сайжруулах чиглээр Сангийн яамны нягтлан бодох газрын орлогч дарга Н.Болормаагийн баг ажиллаж байгаа. Дөрөвдүгээр ажлын хэсэг нь эрдэс баялагийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр Уул уурхайн яамны уул уурхайн хэлтсийн дарга Б.Нэргүй гуай ахлан ажиллаж байна. Тавдугаар ажлын хэсэг нь ашигт малтмалын нөөц ашигласны татвар, жишиг үнийг тогтоох, ойлгомжтой болгох зорилгоор нилээд их хэмжээний тооцоо судалгаа хийсэн байгаа. Энэ чиглэлээр Эрдэнэт үйлдвэрийн Д.Галбаатар гуай ахлан ажиллаж байна. Бид ажлын хэсгийн 5 дугаар сарын 25- ны хурлаар дэд хэсгүүдийн явцтай танилцаад 3,4,5 дугаар ажлын дэд хэсгийн танилцуулгыг Үндэсний зөвлөлд оруулахаар шийдвэрлэсэн.

Б.Дэлгэрмаа: “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах” дэд хэсгийн тайланг сонсоё.

Б.Нэргүй: Дөрөвдүгээр ажлын хэсгийн ажлыг хоёр үе шатаар хийхээр төлөвлөсөн. Үүнд: Томоохон гэрээ хэлэлцээрийг цаасан болон цахим хэлбэрээр цуглуулж, дараа нь нийтэд цахим хэлбэрээр ил тод болгохыг зорьсон. Өнөөдөр бид эхний үе шат буюу гэрээг цуглуулах ажил дээр явж байна. Бид төлөвлөсөн ажлуудаа хувааж аваад ажиллаж байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарын гэрээг ил тод болгохын ач холбогдлыг нийтээр болон гэрээнд оролцогч талууд мэдэх боловч нэгдсэн ойлголтод хүрч чадахгүй байна. Үүнийг нэгдсэн нэг ойлголтод хүргэх талаар бид ажиллаж, тэр талаар судалгаагаа хийж байна. Засгийн газраас олборлох үйлдвэрлэлийн салбар дахь гэрээг ил тод болгохоор багагүй ажил хийсэн байгаа. Үүнд, Засгийн газрын 222 дугаар тогтоол, Хөрөнгө оруулалтын гэрээ, Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тэдгээрийн хэрэгжилтийг нийтэд ил тод болгох ажлыг салбар хариуцсан сайдад даалгасан тогтоол гарсан байгаа. Мөн тодорхой гэрээ тухайлбал, Оюутолгойн гэрээ болон зарим концессийн гэрээг ил тод болгохоор цахим хэлбэрээр нийтэд хүргэж байна.Түүнчлэн хэлэлцүүлэг зохион байгуулж, Засгийн газартай байгуулсан гэрээг ил тод болгохоор чармайж ажиллаж байна. Энэ талаар нээлттэй нийгэм форум судалгаа хийж байна. Цаашид бид дараах хоёр асуудлыг анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үүнд, нэгдүгээрт иргэний нийгмийн байгууллагууд гэрээг байгуулсаны дараа бус өмнө нь бүх үе шатанд нь оролцож, гэрээний төслийг ил болгох, гэрээнд иргэний нийгмийн байгууллага мэргэжлийн холбоодын саналыг авч байх, Хоёрдугаарт чухам ямар гэрээг ил тод болгох вэ гэдэг дээр нэгдсэн саналд хүрэхээр ажиллаж байна. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Нэргүй гуайд баярлалаа. Гишүүд цагаа бариарай. Санаачилгын тайланг аудитаар баталгаажуулах сэдвээр гуравдугаар ажлын дэд хэсгийн танилцуулгыг Сангийн яамны НББ-ийн газрын ахлах мэргэжилтэн Б.Болормаа танилцуулна.

Б.Болормаа: Бид нэгдүгээрт, ажлын хэсгийн зорилго, хоёрдугаарт, багийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн хуралдааны талаар болон юу хийсэн талаар гуравдугаарт, ямар үр дүнд хүрсэн, хэрхэн шийдвэрлэж байгаа талаар товч танилцуулна. Манай ажлын хэсэг нь ОУИТБС-ын тайлангийн маягт түүнийг нөхөх зааврыг дахин хянаж үзэх, Засгийн газрын мэдээлэл цуглуулж байгаа үйл явцыг нягталж үзэх, компанийн болон засгийн газрын байгууллагуудын аудитын асуудлыг хэрхэн яаж зохицуулах вэ гэсэн асуудлыг шийдвэрлэх зорилготой. Үүнд, төр, компани, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон 10 хүний бүрэлдхүүнтэй. Бид ажлын хэсгийн хурлын 3 удаа зохион байгуулсан. 54-60 хувийн ирцтэйгээр оролцсон.

Ажлын хэсгийн нэгдүгээр зорилтын хүрээнд 2014 онд тайлан гаргасан 900 гаруй компаний 691 ажилтанд судалгааны асуулт илгээж компаниудаас 130 хариу хүлээн авсан. Судалгаанд хамрагдсан компаниуд тайлан гаргахад ойлгомжгүй байсан асуудлын талаар 11 санал илэрхийлсэн бөгөөд маягттай холбоотой 7, цахим тайлангийн системтэй холбоотой 4 санал байсан. Судалгааны үр дүнгээс харвал маягт, түүнийг бөглөх заавартай холбоотой дараах 6 асуудал ойлгомжгүй байгаа тул анхны зөрүүг нэмэгдүүлж байна. Энэ зорилтын хүрээнд ажлын хэсэг ярилцаад маягт бөглөх зааварт оруулах өөрчлөлтүүдийг тодорхойлж байна. Үүнийг 2015 оны 10,11 сард багтаан Сангийн яамаар батлуулахаар төлөвлөж байна.

Гуравдугаар зорилтын хүрээнд төрийн байгууллагын тайлан гаргасан 46 ажилтанд судалгааны асуулт илгээж 8 хариу хүлээн авч, Төв аймгийн төрийн сангийн ажилтантай уулзаж тодруулга авсан. ОУИТБС-ын тайланг гаргахдаа ихэнх байгууллага цаасан мэдээллээс шүүж боловсруулж байна, зарим төрийн байгууллага өөрийн мэдээллийн системээс автоматаар авдаг, орон нутагт тайлан бэлтгэж илгээх ажилтан тодорхойгүй, маргаан үүссэн, цаасан мэдээллээс шүүж бэлтгэдэг учир хүнээс хамаарсан алдаа гарах магадлалтай байгаа нь судалгаагаар батлагдсан. Иймд аймгийн засаг даргын тамгын газрын Төрийн сангийн хэлтэс орон нутгийн тайлангаа нэгтгэж гаргахад зохицуулах саналтай байна. Түүнчлэн дөрөвдүгээр зорилтын дагуу ОУИТБС-ын стандартын дагуу ил тод болгох зарим мэдээллийг тодорхой маягтад оруулах боломжтой юм гэж үзээд нэмэлт маягт боловсруулан Ашигт малтмалын газраас санал авахаар ажиллаж байна.

Ажлын хэсгийн тавдугаар зорилтын хүрээнд стандартын тавдугаар шаардлага болон Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төслийн 11.7, 11.8, 12.7, 12.9 заалтууд зааснаар тухайн байгууллага, аж ахуйн нэгжүүд нь аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн ОУИТБС-ын тайланг гаргаж байхаар тусгасан тул ОУИТБС-ын тайланг тусгайлан аудит хийлгэх шаардлагагүй гэж үзсэн. Мөн Засгийн газрын байгууллагуудын тайланд хэрхэн аудит хийх талаар Үндэсний аудитын газартай санал солилцсон. Үүнд, Сангийн сайдын 19 тоот албан бичиг явуулж тодруулга авсан боловч Үндэсний аудитын газар өнөөгийн нөхцөл байдлыг ойлгоогүй

хариу ирүүлсэн. Үүнийг бид дахин ярилцаж байгаа, энэ нь тодорхой хугацаа шаардах ажил байгаа. Ингээд тавдугаар зорилтын хүрээнд тодорхой зөвлөмж боловсруулж гаргана. УИХ-д өргөн барьсан хуулийн төслийн 11.7, 11.8, 12.7, 12.9 дэхь заалтуудтай холбогдсон асуудлуудыг тодорхой болгохгүй бол амьдралд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болзошгүй гэж харж байгаа байгаа. Энэ талаар ажлын алба болон Үндэсний аудитын газартай хамтран ярилцаж, улам тодорхой болгох шаардлагатай байгаа тухай ажлын албанд хүсэлт гаргасан зэрэг ажлуудыг хийгээд байна. Бид энэхүү зорилтуудын хүрээнд холбогдох зөвлөмж гаргах, зохих маягтыг Сангийн сайдаар батлуулах боломжтой гэж харж байна. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Өнөөдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанд Үндэсний аудитын газрын дарга, Ерөнхий аудитор Н.Зангад оролцоно гэсэн боловч ирсэнгүй. Гэхдээ бид энэ асуудлаа цаашид ярилцаж, шийдүүлэх болно. Одоо “Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд хууль жигд, ялгаваргүй үйлчлэх, АМНАТ, жишиг үнийн асуудлыг ойлгомжтой болгох” асуудлаар тавдугаар ажлын дэд хэсгийн танилцуулгыг сонсоё.

Д.Галбаатар: Уул уурхайн салбарт олборлолт явуулж байгаа компаниудын үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулдаг. Бид хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа. Хуулийн дагуу зохицуулагддаггүй ганц асуудал нь борлуулалтын үнэлгээ юм. Борлуулалтын үнэлгээг төрийн захиргааны байгууллага журамлана гэж хуулинд заасан байдаг. Тийм учраас зохицуулж болдоггүй, **шударга биш төлбөр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэж уул** уурхайн салбарынхан мэдэж байгаа. Энэ чиглэлээр олон ажлууд хийгдэж байна. Нааштай асуудлууд гарч байна. Жишээлбэл, 2011 онд Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ 8821 доллар байсан бол 2014 он 6859 доллар болтлоо уналаа. Эрдэнэт үйлдвэр хямралын үед ашгийн төлөвлөгөөг бараг дөрөв дахин нэмэгдүүлсэн. Ийм нөхцөл байдалд яаж ажиллах вэ гэхээр орлогоо нэмэгдүүлэх, өртөгт зардлаа хямдруулах бодлогыг барьж ажилласан. Уул уурхайн бүх үйлдвэрүүд ингэж ажиллаж байгаа. Нөгөө талаас улсын өмнө хүлээсэн үүрэг, улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх татваруудаа бараг биелүүлэн. Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зөрүүг бид тооцож үзсэн. Энэ зөрүүнээс болж уул уурхайн компаниудад татварын дарамт нилээд их байна. Ашигт малтмалын хуучин хууль дээр борлуулалтын орлого гэсэн нэр томъёо байсан. Өнөө үед ихэнх үйлдвэрүүд хагас боловсруулсан түүхий эд үйлдвэрлэж байна. Манай хувьд зэс агуулсан зэсийн баяжмал үйдвэрлээд түүнийгээ экспортонд гаргаж байна. Энэ татварыг авч үзэхэд, бидний үйлдвэрлэж гаргаж байгаа зэсийн баяжмалаас тооцохгүй цэвэр зэсээс тооцдог, 2014 оны тооцооллыг авч үзэхэд 50 гаруй тэрбум төгрөгний зөрүү гарч байна. Хуулиар бол бид 15-16 хувийн татвар төлөх ёстой. Гэтэл татварын буруу тооцоолол буюу хиймэл аргачлалаас болоод бараг 4 хувийн татварыг хуулиас илүү төлж байна. Нэгэнт хуулийн заалтаар ашигт малтмалын нөөц ашигласны татварыг зохицуулахгүй, Татварын ерөнхий газрын журмаар зохицуулж байгаа учраас иймэрхүү дүр зураг ажиглагдаж байна. Харин Оюутолгой дээр тогтвортой байдлын гэрээг Засгийн газар дэмжиж байгаа мөртлөө Эрдэнэт үйлдвэрээс бараг 4 дахин их татварыг авч байгаа нь шардга биш юм. Саяхан Эдийн засгийн байнгын хорооны дарга Батсуурь гуай

ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татварын талаарх асуудлыг хэлэлцэж байгаа талаар ярьлаа. Бид үүнээс үүдээд бүх зүйлүүдийг ойлгомжтой байлгах асуудлыг тавьж байна. Татварын зөрүүнээс болоод үйлдвэр аж ахуйн газруудын эдийн засгийн төлөвлөгөө нь сайн биелэгдээд байдаг, санхүүгийн байдал нь муудаад байдаг. Яагаад гэвэл үйлдвэрлээгүй бүтээгдэхүүнээс татвар төлж байгаа учраас түүнийгээ борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх эсвэл зардлаа бууруулах замаар нөхдөг юм. Ийм учраас гаднаас зээл авдаг, өртэй болдог, улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа хэдий боловч 380 орчим сая долларын балансын өртэй байна. Үүний гол шалтгаан нь ашигт малтмалын нөөц ашигласны татварыг буруу тооцоолж, буруу аргачлалаар тооцож байгаатай холбоотой гэж үзэж байна. Манай төмрийн салбар, жоншны салбар жишиг үнийг гэрээний үнээр тооцох Засгийн газрын тогтоол гарсан, одоо ганцхан зэс үйлдвэрлэгч нарийн өмнө энэ асуудал тулгарч байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоос тооцдог байсан хуучин аргачлалдаа ашиглаач ээ гэж хэлмээр байна. Ер нь байгалийн баялаг ард түмний мэдэлд байдаг учраас хуучин ашигт малтмалын хуулинд маш тодорхой заасан байсан. Тухайлбал, зэс-5 %, нүүрс-2,5% гэх мэтчилэн маш тодорхой, хэнд ч ойлгомжтойгоор хуулиндаа заасан байсан, үүнийг эргэж оруулах саналыг бид хөндөж байна. Хоёрдугаарт, дэлхийн түвшинд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ямар хэмжээгээр төлдөг талаар судалгаа хийсэн. Ингээд аваад үзэхээр Монгол Улс маш өндөр буюу 5-35 хувийн татвар авдаг нь дээгүүр орж байна. Гэтэл хамгийн дээд хэмжээ нь 8 хувь байдаг байна. 1990-аад онд Эрдэнэт үйлдвэрт сэхээтнүүдийн иргэний хөдөлгөөн гэж үүсэж байсан. Тэр үед ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг оросын талаас авах асуудлыг хөндөж байсан. Хууль байхгүй байхад оросууд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 8 хувиар тогтоож, манай талд ногдох зээлээс хөнгөлж байсан. Тэр үед Монгол улсын хууль 1996 онд гарч, зэс-5 % байсан. Америкт 5 хувь байсан одоо ч баяжуулалтын орлогоос 5 хувь татвар авч байна, Оросын татвар 8 хувь байсан хэвээрээ л байгаа, гэтэл манайд 68 хувь болгосон. Үнэ өсөөд байхад оролцогч 2 тал бие биедээ хувь хүртээдэг тал бий. Жишээлбэл, зэсийн баяжмалын арилжааг тэлье гэсэн бодлого бий. Үүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2-6 хувьтай байх нь зүйтэй гэсэн саналыг боловсруулсан байгаа. Одоо хуулин дээр 5000 хүртэл гэж заасан байгаа, үүнээс тооцож байсан интервалаа 2-6 хувь болгоё гэсэн асуудал тавьж байна. Цаашилбал давхар татварын асуудал байна. Тухайлбал, хүдэр дээр 30 хүртэлх хувиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтоож байна. Ингэснээр Эрдэнэт үйлдвэрийн ашиглалтын явцад бий болгон исэлдсэн хүдрийн овоолго гэж нэрлэдэг хүдрийг авдаг байсан газрууд нь татвар өндөр болон учраас худалдаж авч чадахаа байсан. Энэ хүдрийн овоолгыг ашиглахаар Эрдмэн, Ачит эх гэдэг компаниуд байгуулагдан ажиллаж байна цаашдаа хэд хэдэн үйлдвэр байгуулагдахаар ажиллаж байна. Гэтэл тэд хүдрээ худалдаж авч чадахаа болисон. Учир нь татвар нь 30 хувь болсон. Иймээс тэд Эрдэнэт үйлдвэртэй хамтарсан үйлдвэр байгуулъя, та нар үүнийгээ үнэгүй өгөөч гэсэн саналыг тэд тавьж байна. Монголд хүдэр экспортод гаргаж байсан түүх байхгүй иймээс үүнийгээ болих хэрэгтэй байна. Харин бид хүдэр зарлаа гээд 30 хувийн татвар биш ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө төлж болно. Дотоодын зэс гаргавал дахиад 5 хувийн татвар авахаар заасан байдаг. Ингээд давхар давхар татвар авдаг систем нь

хуулиндаа байхгүй мөртлөө журмаар гарч ирээд байна. Үүнийг анхаарах хэрэгтэй байна. Гуравдугаарт, уул уурхайн салбарын эрсдэлийн санг 3 хувиар байгуулах саналыг хөндөн тавьж байна. Банкууд эрсдэлийн санг 5 хувиар байгуулдаг. Ашигт малтмалын нөөц ашигласны татварын 10 хувийг суманд, 20 хувийг аймагт үлдээнэ гэсэн заалт хуучин хуульд байсан, харамсалтай нь хэрэгжиж чадаагүй. Одоо яригдаж байгаа учраас энэ асуудлыг хойшлуулж болно гэсэн саналтай байна. Гол зүйл нь өнөөдөр хэрэгжиж байгаа татвар тооцох аргачлалын 2-ын 3-ыг барьж ажиллаач ээ гэсэн санал байгаа. Үүнд хүдэр болон баяжуулах баялгийн металын чанарыг баталгаажуулсан байх ёстой гэсэн заалт бий. Эрдэнэт үйлдвэр баталгаат сертификатуудыг авсан, олон улсын томоохон лабораториудтай хамтарч ажиллаж байгаа учраас энэ асуудал шийдэгдэх боломжтой гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Дэлгэрмаа: Одоо хэлэлцүүлгийн цаг маш бага байгаа тул гишүүд ажлын дэд хэсгүүдтэй холбоотой санал, асуултаа товчхон хэлнэ үү.

Н.Дорждарь: Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн зохицуулагч, Дэлгэрмаа даргаас асуух асуулт байна. Таван дэд ажлын хэсгүүдээс гаргаж байгаа зөвлөмж нь манай санаачилгын Үндэсний зөвлөл ажлын хэсгээс ямар байдлаар шийдвэр болж гарах вэ? Жишээлбэл, ажлын хэсгүүд нь сайн ажил хийсэн байна, гэхдээ санал нийлэх, нийлэхгүй асуудлууд байна. Тухайлбал, гуравдугаар ажлын хэсгийн зөвлөмж дээр аудитлагдсан тайлан дээр үндэслэгдсэн учраас аудит хийлгэх шаардлагагүй гэх юмуу, намар гэхэд холбогдох тушаал шийдвэрүүдийг гаргуулна гэж ярьж байгаа нь санаачилгын ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн байр суурь мөн үү гэдэгт би эргэлзээд байна.

Б.Дэлгэрмаа: Юуны өмнө 1,2 дугаар ажлын хэсэг ерөөсөө ажиллаагүй, төлөвлөгөөнийхөө 30 хувьтай байсан. Өнөөдөр Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар бэлэн болсон гурван ажлын хэсгийн ажлыг хэлэлцээд хуралдаанаараа шийдвэр гаргана. Тухайн ажлын хэсгийн асуудлуудын чухам юун дээр санал зөрж байна гэдэг байр сууриа илэрхийлж, ажлын дэд хэсэгт оролцоод, нэгдсэн хуралдаанаар энэ асуудлыг шийдэх бус харин нэгдсэн хуралдаанд шийдвэр гаргаад явах нь зүйтэй гэсэн учраас жилдээ 2 удаа хуралдахаар тогтсон. Иймээс тодорхой болохгүй байгаа асуудлын хүрээнд ажилдаа оролцоод явах хэрэгтэй гэсэн саналтай байна. Өнөөдрийн гурван ажлын хэсгүүдийн ярьсан зүйл хуралдаанаараа шийдвэр болоод явна. Жишээлбэл, 3,4,5 дугаар ажлын дэд хэсгүүдийн гаргасан шийдвэрийг хаана ямар баримт бичгүүдэд тусгаж, төр засгийн шийдвэр болоод явах уу эсвэл тодорхой хуулинд тусгаад явах уу гэдэг саналаа оруулаад шийдвэрлэж явах ёстой. Дорждариа жаахан ажил хэрэгч байдлаар ажлын дэд хэсгүүдтэй уулзаж, ажилдаа оролцмоор байна.

Н.Дорждарь: Нэгдүгээр ажлын хэсэг огт ажиллаагүй биш, жаахан ажилласан. Эдгээр ажлын хэсгүүдийн ажилтай танилцах бололцоо өнөөдөр л олдож байна. Үүнд санаа оноогоо хэлэх боломжгүй юм шиг ойлгогдож байгааг гайхаж байна. Яагаад гэвэл ажлын хэсэг шийдвэрээ зөвшилцлийн журмаар гаргах ёстой байх. Ажлын

хэсгийн шийдвэр нь шууд Үндэсний зөвлөлийн шийдвэр болоод явна гэж өмнө нь тохирсон юм уу? би сайн мэдэхгүй байна.

Б.Дэлгэрмаа: Уучлаарай, бид 5 дугаар сарын 25-нд ажлын хэсгийн хуралдаан зохион байгуулж, энэ асуудлуудаа ярилцаад, дараа нь гишүүдэд цахимаар явуулж санал аваад өнөөдрийн хуралдаанд оруулахаар шийдсэн байгаа.

Н.Дорждарь: Өнөөдөр тэгээд танилцуулж байгаа юмуу, шийдвэр гаргаж байгаа юм уу?

Б.Дэлгэрмаа: Шийдвэр гаргана.

Н.Дорждарь: Тэгвэл саналаа хэлж болох уу?

Б.Дэлгэрмаа: Одоо саналаа хэлж болно.

Н.Дорждарь: гуравдугаар ажлын хэсгийн зөвлөмж дээр компаниудын тайлан нь *аудитлагдсан тайлан дээр үндэслэгдэн бэлтгэгдэг* тул аудит хийлгэх шаардлагагүй гэсэн байна. Бид нар энэ асуудлын олон удаа ярьж байсан. Бүх компаниуд аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлэхгүй байгаа, яагаад гэвэл хугацааны хувьд аудит хийлгэж амжаагүй эсвэл жижиг компаниуд аудит хийлгээгүй байдаг. Зөвхөн компанийн захирал, нягтлан бодогч нар аудитлагдсан тайлан дээр үндэслэсэн ОУИТБС-ын тайланг гаргасан гэсэн гарын үсэгтэй бичиг л ирдэг. Бид нар аудиторудтай ярьж үзсэн, энэ бол аудитлагдсан дүн биш гэж хэлдэг. Хоёрдугаарт, роялти, өсөн нэмэгдэх роялти хоёрыг хольж ярьж байгаа. Өсөн нэмэгдэх роялти гэдэг нь гэнэтийн ашгийн татвар дээр үндэслэн гарч ирсэн. Роялти гэдэг нь баялагийн эзэн тухайн баялагийг ашиглуулсны төлбөр юм. Үүнийг улс орны байдлаас хамаараад яаж, хэдэн хувиар яаж тогтоох вэ гэдэг нь ялгаатай байдаг. Өнөөдөр борлуулалтын орлогоос биш баяжмал дахь цэвэр бүтээгдхүүнээс тооцож байгааг буруу гэж байна. Үүнтэй би санал нэгдэхгүй байна. Хэрвээ үүн дээр шийдвэр гаргаж байгаа бол санал нийлэхгүй байна.

П.Эрдэнэжаргал: Хэдэн санал байна. Нэг нь гэрээний ил тод байдалтай холбоотой асуудал байна. Үүнд талууд нэгдсэн ойлголтод хүрэх асуудал үүсэж байна. Өнгөрсөн оны сүүлээр болсон төр, компани, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон форум болсон, бидэнд ямар ч асуудал байхгүй. Бид гэрээнүүдээ авчихсан, энэ оны эхний Үндэсний зөвлөлийн хуралдаанаар гэрээнүүдээ ил тод болгоё гэж ярьсан, эхний ээлжинд батлагдсан гэрээнүүдээ ил тод болгох бүрэн бололцоотой гэж үзэж байна. Ажлын хэсгүүдийн танилцуулгаас харахад ойлголтын зөрүү гэрээний төслүүд дээр байна гэж бодож байна. Бид энэ ажлын хүрээнд 2013 оны тайландаа гэрээнүүдээ авсан байгаа, эхлээд батлагдсан гэрээнүүдээ ил тод болгох нь илүү шуурхай байх гэсэн санал байна. Өнөөдрийн хуралдаанаар илүү танилцуулга хийх юм байна гэж ойлгож байсан ч хөтөлбөрөөс харахад шийдвэр гаргах асуудлууд тусаагүй юм шиг байна. Буруу ойлгосон бол хүлцэл өчье. Жишээлбэл, гуравдугаар ажлын хэсгийн танилцуулгад 18 төрлийн өөрчлөлт оруулах зөвлөмж гаргасан гэж байна. Үүнийг би хараагүй учраас Үндэсний зөвлөлийн гишүүний хувьд баталж

чадахгүй нь. Энэ мэдээллийг өгөөд дараа нь Үндэсний зөвлөлийн хурлаа хийгээд шийдвэрээ гаргах санал байна.

Өнөөдрийн хуралдаанд хатагтай Клейр Шорт оролцож байгаад үнэхээр их баяртай байна. Энэ завшааныг ашиглаад Монгол Улсад ОУИТБС хэрхэн хэрэгжиж байгаа талаар иргэний нийгмийн өмнөөс өөрийн байр сууриа илэрхийлье гэж бодлоо. Санаачилга маань гурван талын тэгш оролцоог хангасан, бусад салбарт жишиг болохоор ийм хэмжээнд хэрэгжиж байгаа. ОУИТБС-ын 8 удаагийн тайлан гаргасан, жилээс жилд мэдээллийн цар хүрээ нь өргөжиж байгаа, үүнд оролцож байгаа бизнесийнхэн, иргэний нийгмийнхэн, төр засгийнхан гарч байгаа амжилтандаа урамшиж, хийж байгаа ажилдаа хүсэл зоригтой байгаагаа хэлэхэд таатай байна. Өнгөрсөн оноос зөвхөн эрдэс баялгаас гадна газрын тос, цөмийн эрчим хүчний салбарууд тайланд хамрагддаг болсон. Хатагтай Таны хэлснээр тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, гэрээний мэдээллийн талаар орж ирсэн. Бид гэрээг ил тод болгохоор 2013 оны тайландаа гэрээнүүдийг авсан байгаа. Иймэрхүү байдлаар бидэнд ахиц дэвшил их гарч байгаа. Цаашдаа бид бүхэн, талууд эрх тэгш оролцоотойгоор энэхүү санаачилгыг улам үр бүтээлтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно гэдгээ хэлмээр байна.

С.Мэндсайхан: Юуны өмнө энэхүү хуралдаанд хатагтай Клейр Шорт оролцож байгаад таатай байна. Миний хувьд Үндэсний зөвлөлийн гишүүнээр 7 дахь жилдээ ажиллаж байна. Долоон жилийн өмнөх байдлыг өнөөдрийн байдалтай харьцуулахад хүрсэн үр дүн мэдрэгдэж байгаад таатай байна. Танд нь гэсэн энэ өөрчлөлт мэдрэгдэж, биднийг сайшааж урам өгсөн талархлаа илэрхийлье.

Монгол улсын эдийн засгийн хэмжээ, цар хүрээ сүүлийн жилүүдэд маш огцом тэлсэн. Энэ нь уул уурхайн салбар түүний дотор олборлох салбарын хөгжлийн “тэсрэлт” эдийн засагт гол нөлөө үзүүлж байгаа. Иймээс статистикийг тодорхойлоход энэ салбарын мэдээлэл маш чухал. Энд уул уурхайн байгууллага, төрийн байгууллагын тайлагналын үнэн бодитой, цаг хугацаандаа байгаа байдал нь сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн гэдэг нь статистикийн байгууллагын үйл ажиллагаанаас харагдаж байгаа. ОУИТБС-ын хүрээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн нэгдсэн чиглэлээр хүсэл зорилго тодорхой үр дүнд хүрч байгаагийн нэг илрэл бол статистик мэдээлэл сайжирч байна, нөгөө талаар тайлагналын зөрүү бага байгаа нь бидний ажлыг маш их хөнгөвчилж байгааг хэлмээр байна.

Энэ туршлага дээрээ үндэслээд Монгол улсын Статистикийн байгууллага Австралийн Статистикийн байгууллагатай хамтран олон улсын түвшинд уул уурхайн салбарын статистикийг иж бүрнээр нь илэрхийлэх аргачлалыг бусад улс орнуудыг урьж, Дэлхийн 13 орон, олон улсын 2 байгууллагатай хамтран НҮБ-ын хэмжээнд боловсруулж байна. Энэ нь байгалийн баялгийг үнэлэх, олборлолтыг бүрэн тооцох, эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг зөв тодорхойлох, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө, хор хөнөөлийг зөв тооцох зэрэг уул уурхайн олборлолттой холбоотой бүхий л асуудлыг багцаар нь шийдэх аргачлалыг олон улсын хэмжээнд боловсруулж байгаа бөгөөд үүнийг байгалийн баялагт суурилсан статистик гэж нэрлэдэг. Энэ ажиллагаанд Монгол шиг нүүрстэй, зэстэй, Орос шиг нефтьтэй, Ази, Ойрхи Дорнодын байгалийн баялаг ихтэй олон томоохон улс орнууд хамтран оролцож байгаа нь бидний олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг

амжилттай хэрэгжүүлж байгаагийн нэг илэрхийлэл юм. Бид энэ аргачлалаа НҮБ-ын албан ёсны чуулган дээр энэ аргачлалаа албан ёсоор танилцуулна.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж саналаа хэлэхэд, ажлын дэд хэсгийнхэн их ажил хийсэн байна. Би Болормаа ахлагчтай гуравдугаар ажлын хэсэгт хандаж хэлэхэд, ОУИТБС-ын тайлангийн маягтыг зөв ойлгомжтой болгох асуудал нь мэдээлэл ойлгомжтой, тайлагналын анхны зөрүү байхгүй болгох бидний зорилгод нийцнэ. Тиймээс тайлангийн маягтыг илүү сайжруулж, боловсруулах шаардлага байгаа гэдгийг бид ойлгож байна. Тиймээс статистикийн байгууллага хуулиараа захиргааны статистик мэдээлэлд зориулагдсан бүхий л маягтын зөвшөөрлийг Үндэсний статистикийн хороонд олгоод, улмаар салбарын сайд нь баталдаг журамтай. Энэ нь ойлголт, тодорхойлолт улсын хэмжээнд нэгдмэл байх, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэлийн давхцал ачаалал олгохгүй зорилготой байх, мэдээлэлүүд албан ёсны статистикт ашиглагдах зохицуулалт юм. Иймээс ажлын дэд хэсэгт статистикийн мэргэжлийн хүмүүсийг оруулж, журмын дагуу Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлийг аваад баталгаажвал илүү бодитой болно.

Б.Дэлгэрмаа: Цаг байхгүй учраас хамгийн сүүлчийн саналыг сонсоё.

Н.Баярсайхан: Өнөөдрийн хуралдаанд шинэ хүмүүс орж ирж байна. Өнөөдрийн хуралдаанд УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Батсуурь Уул уурхайн сайд Р.Жигжид, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан мөн хатагтай Шорт нар оролцож байгаад баяртай байна. Ажлын хэсгүүдийн танилцуулга, гаргасан зөвлөмжийг харахад зарим зүйл дээр санал нийлэхгүй байна. Тухайлбал, ажлын гуравдугаар хэсгийн тавдугаар зорилтын хүрээнд гарсан зөвлөмж дээр санал нийлэхгүй байна. Түрүүн Дорждарь ч хэлсэн байгаа. Бид санаачилгын тайлангийн мэдээ мэдээллийн чанарын асуудалд санаа зовж байгаа. Санаачилгын тайланд аудит хийлгэх нь томоохон компаниудад дарамт учруулж болзошгүй байна гэж дүгнэлт хийсэн байна. Энэ нь амьдрал дээр жижиг, дунд компаниудад илүү дарамттай байдаг гэж ярьдаг. Санаачилгын тайланг аудитлахгүй байх зөвлөмж нь мэдээний чанарт яаж нөлөөлөх вэ, үүнд дүгнэлт хийсэн үү? Үүнийг дахин хэлэлцэж албан ёсоор саналаа оруулмаар байна. Ажлын дэд хэсгүүд тодорхой ажлуудыг сайжруулахын тулд ажиллаж байгаа гэтэл тодорхой хэмжээнд хүрсэн ажлуудыг ухраах юм уу дордуулах зөвлөмж гараад ажил хэрэг болчихвий гэж санаа зовж байна. Ийм учраас энэ асуудал дээр иргэний нийгмээрээ хэлэлцэж саналаа оруулах саналтай байна. Өнөөдөр та арай батлахгүй юм байна гэж ойлголоо. Өнөөдрийн Үндэсний зөвлөлийн хурлын тэмдэглэлд тэмдэглүүлэхийг хүсэж, тодорхой саналыг хэлмээр байна. Шийдлийн Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд маань эдийн засгийн хямралтай энэ үед уул уурхайн салбараас орлогыг бий болгоно гэж хэлсэн. Энэ нь орон нутагт гажуудал бий болж байна. Орхигдсон газруудыг хянан олборлож нөхөн сэргээнэ гэсэн агуулгаар нөхөн сэргээлт хийдэг компаниудаар олборлолт хийлгэж эхэлсэн. Ингэж лицензгүйгээр олборлолт хийж байгаа нь өнөөгийн уул уурхайн салбарын төлөвшиж байгаа засаглалыг муутгах, авилга бий болоход түлхэц болж байна. Нөгөө талаас уул уурхайн орлогын тодорхой хувийг орон нутагт үлдээнэ гэж байгаа нь сайн хэрэг, гэхдээ уул уурхайгүй орон нутагт яах вэ, хөгжлийн ялгаатай

байдал үүсэж болзошгүй байгаа. Мөн орон нутагт уул уурхайн орлогыг удирдах чадавхи байхгүй байгаа ийм үед уул уурхайн салбарыг замбараагүй болгох, авилга хээл хахуулийг орон нутаг руу шилжүүлж байгаа юм биш байгаа гэсэн болгоомжлолыг Ерөнхий сайдад уламжилж өгөхийг Ерөнхий сайдын ахлах зөвлөхийн хувьд танаас хүсэж байна. Энэ байдал нь уул уурхайн салбарын төлөвшиж байгаа, цэгцэрч байгаа өнөө үед сөргөөр нөлөөлөхөд ихээхэн хувь нэмэр болно гэдгийг уламжилж өгнө үү. Баярлалаа.

Б.Дэлгэрмаа: Үндэсний зөвлөлийн эрхэм гишүүд та бүхэнд маш их баярлалаа. Ингээд хуралдаанаас дараах шийдвэрийг гаргахаар шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

Шийдвэр нэг: Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах асуудлын хүрээнд ажлын хэсгийн ажлыг үргэлжлүүлэн, Үндэсний зөвлөлд эцсийн шийдвэрийг танилцуулахыг даалгав.

Б.Дэлгэрмаа: За зөвшөөрч байгаа гишүүд гараа өргөнө үү. За бүгд зөвшөөрч байна, баярлалаа.

Шийдвэр хоёр: ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах асуудлаар тайлангийн маягтын өөрчлөлтийг боловсруулан дуусгаж, Үндэсний статистикийн хороонд танилцуулан, зохих шийдвэрийг гаргуулахыг ажлын албанд даалгав.

Б.Дэлгэрмаа: Шийдвэрийн төслийн зөвшөөрч байгаа гишүүд гараа өргөнө үү. Татгалзаж байгаа гишүүд байна уу?

П.Эрдэнэжаргал: Эргэлзээ байна, ажлын албанд даалгав гэдэг нь Үндэсний зөвлөлөөр орж ирэхгүй гэсэн үгүү?

Б.Дэлгэрмаа: Дахин Үндэсний зөвлөлөөр орох шаардлагагүй. Ингээд гурван гишүүн татгалзаж, бусад нь зөвшөөрсөн байна.

Шийдвэр гурав: Уул уурхайн салбарын АМНАТ, жишиг үнийн асуудлыг ойлгомжтой болгох асуудлын хүрээнд, Танилцуулгыг бүх оролцогч талууд сайтар судалж, хэлэлцүүлгийн эцсийн шийдвэрийг Үндэсний зөвлөлд танилцуулахыг даалгав.

Б.Дэлгэрмаа: Шийдвэрийн төслийг зөвшөөрч байгаа гишүүд гараа өргөнө үү. За бүх гишүүд зөвшөөрсөн байна.

Н.Баярсайхан: Хоёрдугаар шийдвэрээ гуравдугаар шийдвэртэйгээ адилхан гаргаж болохгүй юу. Дахин танилцаж ярилцаж, ажлын хэсэг дахиад хуралдая. Маягт гэдэг бол санаачилгын маш чухал үндсэн баримт бичиг учраас явцуу байдлаар хэлэлцэх нь буруу байх.

Б.Дэлгэрмаа: Гишүүд Баярсайханы саналыг юу гэж үзэж байна, өөрөөр хэлбэл Үндэсний зөвлөлөөр оруулахыг дэмжиж байна уу?

С.Мэндсайхан: Хуулиараа маягт батлуулахад Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлөөр ороод батлагддаг. Миний бодлоор Үндэсний зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлэхгүйгээр Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн хурлыг өргөтгөсөн байдлаар хийгээд та нар оролцож, ажлын хэсэг дээр урьдчилж саналаа өгөөд саналаа тусгасан нь зүгээр байх. Та бүхнийг өргөтгөсөн хуралдаанд оролцохыг урьж байна.

Б.Дэлгэрмаа: Энэ бол хамгийн зөв шийдвэр байна.

Н.Баярсайхан: Тэгвэл ийм маягаар шийдвэртээ оруулъя.

Б.Дэлгэрмаа: Шийдвэртээ ингэж оруулсан байгаа. За манай Үндэсний зөвлөлийн арван гуравдугаар хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд төлөөлөгчөөр оролцсон эрхэм хүндэт хатагтай Шорт болон дагалдан ирсэн төлөөлөгчдөд баярлалаа. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хуралд 15,45 цагт өндөрлөв.


Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Дэлгэрмаа

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн
ажилтан



А.Отгонтунгалаг